



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар

8/14

Модот

Мод бэлтгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны өдрийн 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны эхний хагас жилд сумын ойн сангаас ойн мэргэжлийн байгууллагуудын үйлдвэрийн ашиглалт, Арчилгааны огтлолт, Цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх модны хэмжээ болон багуудын ахуйн хэрэгцээнд цэвэрлэгээний ажил, уламжлалт бүтээгдэхүүн бэлтгэх модны хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хуваарьт орсон ойн мэргэжлийн байгууллагуудын Үйлдвэрийн ашиглалтын огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж бэлтгэсэн модны 100м³ тутамд өөрийн хөрөнгөөр 2 га, Арчилгааны огтлолт, Цэвэрлэгээний огтлолтоор ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж бэлтгэсэн модныхоо 100м³ тутамд өөрийн хөрөнгөөр 1 га талбайд, ойн цэвэрлэгээний ажлаар ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж байгууллага бэлтгэсэн хэрэглээний модныхоо 100м³ тутамд өөрийн хөрөнгөөр 0,5 га-д ойжуулалт хийх ба Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар нас гүйцсэн ургаа нойтон мод ойгоос бэлтгэсэн иргэд огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ойжуулалтын ажлыг чанартай зохион байгуулаж тарьж ургуулахыг ойн мэргэжлийн байгууллагуудад, хяналт тавьж ажиллахыг ойн ангийн дарга (П.Баярсайхан)-д үүрэг болгосугай .

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Энхбаяр), байгаль хамгаалагч (Ж.Тодбилэг)-т нарт тус тус хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 2025 оны
... дугаар сарын 23-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолт, арчилгаа цэвэрлэгээний огтлолт, цэвэрлэгээний ажил, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бэлтгэх модны хэмжээ

Огтлолтын төрөл	Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Гансоёмбо ХХК	Буман ногоон төгөл ХХК	Мэргэн засаг ЗГБХН	Бэрх эрдэнэ ХХК	Баянмод баг	Хужхан баг	Согоот баг	Нугаар баг	Сумын хэмжээнд	Нийт бэлтгэх модны хэмжээ
Үйлдвэрлэлийн ашиглалт	хэрэглээ	Шинэс	м³	80									80
	Дүн			80									80
	Түлээ	Шинэс	м³	60									60
	Дүн			60									60
Бүгд				140									140
Арчилгааны огтлолт	Хэрэглээ	Шинэс	м³		20	20							20
	Дүн				20	20							20
	Түлээ	Шинэс	м³		10	10							10
	Дүн				10	10							10
Бүгд		Шинэс	м³		30	30							30
Цэвэрлэгээний огтлолт	Хэрэглээ	Шинэс	м³	80	120	120	80						400
	Дүн			80	120	120	80						400
	Түлээ	Шинэс	м³	200	200	200	200						800
	Дүн			200	200	200	200						800
Бүгд				280	320	320	280						1200
Уламжлалт бүтээгдэхүүн	Хэрэглээ	Шинэс	м³									40	40
	Дүн											40	40
	Түлээ	Шинэс	м³									20	20
	Дүн											20	20
Бүгд			м³									60	60
Цэвэрлэгээний ажил	Хэрэглээ	Шинэс	м³	40	40	40	40	40	40	40	40		320
	Дүн		м³	40	40	40	40	40	40	40	40		320
	Түлээ	Шинэс	м³	40	40	40	40	600	160	200	160		1280
	Дүн		м³	40	40	40	40	600	160	200	160		1280
Бүгд			м³	80	80	80	80	640	200	240	200		1600
Нийт дүн			м³	500	430	430	360	640	200	240	200	60	3060
Нийт хэрэглээ			м³	200	180	180	120	40	40	40	40	40	880
Нийт түлээ			м³	300	250	250	240	600	160	200	160	20	2180